

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Малчин сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: УВА-2023/174/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Улаангом хот
2023 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газар,
Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь
Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn
Аудитын менежер: М.Бат-Амгалан
Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn
Гэрээгээр аудитыг гүйцэтгэсэн "Увс Финанс аудит" ХХК
аудитор: Я.Тунгалаг
Утас: 99459698 Цахим хаяг: anu_gantun@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

МАЛЧИН СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ТӨВИЙН ДАРГА З.ЦЭРЭНХҮҮ
ТАНАА

2023.08.24 № УВА-0223/174/НА-СТА-ТШЗ
танай -ны № -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Малчин сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Малчин сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Эрүүл мэндийн газраас үнэ төлбөргүй 5,687.8 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 1,100.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, Орон нутгийн хөгжил сангаас 18,000.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, барилга байгууламжийн засварт 10,000.0 мянган төгрөг, Цахим төслөөс /интернетийн сүлжээ/ үнэ төлбөргүй 582.8 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 320.0 мянган төгрөгийн бусад үндсэн хөрөнгө тус тус ирсэн байна.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

0200200481

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	Error! Bookmark not defined.
Асуудлыг онцолсон хэсэг	
Аудитын гол асуудал	
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	
4. АУДИТЫН ТАЙЛАН	
4.1 Ерөнхий зүйл	
4.2 Материаллаг байдал	
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	
4.5.1 Завсрын аудитын талаар.....	
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
НА	Нийцлийн аудит

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

		/Төгрөг/	
Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	84,380,949.28	70,886,012.99
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	17,433,945.81	29,711,560.82
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	17,433,945.81	29,711,560.82
3121	Төгрөг	17,433,945.81	29,711,560.82
31211	Төрийн сангийн харилцах	17,433,945.81	29,711,560.82
33	АВЛАГА	47,097,200.00	00.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	47,097,200.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	19,849,803.47	41,174,452.17
351	Түүхий эд материал	00.00	8,301,751.90
35130	Эм боох материал	00.00	8,301,751.90
354	Хангамжийн материал	19,849,803.47	32,872,700.27
35420	Аж ахуйн материал	17,923,825.47	30,194,256.27
35440	Түлш, шатах тослох материал	120,000.00	120,000.00
35460	Хүнсний материал	1,230,978.00	1,983,444.00
35470	Бусад хангамжийн материал	575,000.00	575,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	637,307,734.70	651,934,288.02
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	637,307,734.70	651,934,288.02
392	Биет хөрөнгө	631,125,734.70	645,752,288.02
39201	Барилга, байгууламж, орон сууц	556,205,588.00	566,205,588.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-45,048,565.52	-60,038,911.64
39203	Авто-тээврийн хэрэгсэл	87,770,000.00	86,220,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-16,675,555.60	-29,495,555.60
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	121,641,163.52	148,883,706.81
39206	Хуримтлагдсан элэгдэл	-78,440,896.79	-84,536,484.28
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	29,808,260.50	38,633,390.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-24,814,259.41	-20,939,445.27
39214	Бусад үндсэн хөрөнгө	900,000.00	1,220,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-270,000.00	-450,000.00
39217	Ном	50,000.00	50,000.00
393	Биет бус хөрөнгө	6,182,000.00	6,182,000.00
39301	Програм хангамж	1,340,000.00	1,340,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,340,000.00	-1,340,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	6,182,000.00	6,182,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	721,688,683.98	722,820,301.01
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	721,688,683.98	722,820,301.01
51	Засгийн газрын хувь оролцоо	721,688,683.98	722,820,301.01
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	256,471,533.00	256,471,533.00
51101	Өмч: - төрийн	256,471,533.00	256,471,533.00
512	Хуримтлагдсан үр дүн	176,465,392.69	177,956,275.10
51210	Өмнөх үеийн үр дүн	176,465,392.69	176,824,658.07
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	1,131,617.03

51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	288,751,758.29	288,392,492.91
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>721,688,683.98</u>	<u>722,820,301.01</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	784,079,045.03	687,453,934.60
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	85,715,453.03	91,446,354.60
120	Нийтлэг татварын бус орлого	85,715,453.03	91,446,354.60
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	85,715,453.03	53,124,593.10
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	00.00	17,433,945.81
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	85,715,453.03	00.00
120005	Түрээсийн орлого		0.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	289,995,792.00	596,007,580.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	408,367,800.00	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	200,094,102.00	4,085,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	4,085,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	26,487,100.00	26,487,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	26,487,100.00	26,487,100.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	63,414,590.00	565,435,480.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	63,414,590.00	565,435,480.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	668,997,777.67	686,322,317.57
21	УРСГАЛ ЗАРДАЛ	668,997,777.67	686,322,317.57
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	629,807,514.67	643,171,586.76
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	346,895,891.71	376,777,098.20
210101	Үндсэн цалин	263,347,465.71	249,459,649.27
210102	Нэмэгдэл	00.00	74,947,312.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,848,000.00	5,054,997.93
210104	Урамшуулал	75,111,335.00	43,535,139.00
210105	Гэрээт ажлын хөлс	3,589,091.00	3,780,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	45,546,155.48	47,085,789.29
210201	Тэтгэврийн даатгал	33,415,129.43	32,459,517.71
210202	Тэтгэмжийн даатгал	3,073,605.56	3,667,039.45
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,432,004.41	2,871,628.00
210204	Ажилгүйдлийн даатгал	602,310.60	717,782.18
210205	Эрүүл мэндийн даатгал	6,023,105.48	7,369,821.95
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22,516,837.00	22,270,315.00
210301	Гэрэл, цахилгаан	838,755.00	691,915.00
210302	Түлш, халаалт	20,498,082.00	20,378,400.00
210303	Цэвэр, бохир ус	1,180,000.00	1,200,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	49,135,505.00	64,744,845.00
210401	Бичиг хэрэг	2,106,300.00	1,737,400.00

210402	Тээвэр, шатахуун	30,938,230.00	39,946,945.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,567,000.00	1,747,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,270,000.00	2,393,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,864,675.00	15,297,200.00
210408	Бараа материал акталсны зардал	2,389,300.00	3,622,500.00
2105	Нормативт зардал	120,080,627.00	74,524,135.30
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	91,289,924.00	61,439,551.30
210502	Хоол, хүнс	28,790,703.00	13,084,584.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	300,000.00	2,040,000.00
210604	Урсгал засвар	300,000.00	2,040,000.00
2107	Томилолт, зочны зардал	700,000.00	2,290,000.00
210702	Дотоод албан томилолт	700,000.00	2,290,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,756,035.00	987,510.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	288,000.00	288,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	110,600.00	140,700.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	55,010.00	151,410.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	48,400.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	636,000.00	319,000.00
210807	Газрын төлбөр	24,728.00	55,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	38,876,463.48	52,451,893.97
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,514,400.00	3,717,800.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	37,362,063.48	48,734,093.97
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	39,190,263.00	43,150,730.81
2132	Бусад урсгал шилжүүлэг	36,600,000.00	23,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	36,600,000.00	23,000,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,590,263.00	2,716,785.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,590,263.00	2,716,785.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	17,433,945.81
213505	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт	00.00	17,433,945.81
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>115,081,267.36</u>	<u>1,131,617.03</u>
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-833,333.10	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>114,247,934.26</u>	<u>1,131,617.03</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /төгрөг/
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>651,266,392.00</u>	<u>660,538,725.81</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	17,433,945.81
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	17,433,945.81
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	17,433,945.81

1200043	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих	00.00	17,433,945.81
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	651,266,392.00	643,104,780.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	408,367,800.00	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	200,094,102.00	4,085,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	1,262,502.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	4,085,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	198,831,600.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	26,487,100.00	26,487,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	26,487,100.00	26,487,100.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	16,317,390.00	612,532,680.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	16,317,390.00	612,532,680.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	633,832,446.19	648,261,110.80
21	УРСГАЛ ЗАРДАЛ	633,832,446.19	648,261,110.80
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	594,642,183.19	605,110,379.99
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	346,895,891.71	376,777,098.20
210101	Үндсэн цалин	263,347,465.71	249,459,649.27
210102	Нэмэгдэл	00.00	74,947,312.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,848,000.00	5,054,997.93
210104	Урамшуулал	75,111,335.00	43,535,139.00
210105	Гэрээт ажлын хөлс	3,589,091.00	3,780,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	45,546,155.48	47,085,789.29
210201	Тэтгэврийн даатгал	33,415,129.43	32,459,517.71
210202	Тэтгэмжийн даатгал	3,073,605.56	3,667,039.45
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,432,004.41	2,871,628.00
210204	Ажилгүйдлийн даатгал	602,310.60	717,782.18
210205	Эрүүл мэндийн даатгал	6,023,105.48	7,369,821.95
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22,396,837.00	22,270,315.00
210301	Гэрэл, цахилгаан	838,755.00	691,915.00
210302	Түлш, халаалт	20,378,082.00	20,378,400.00
210303	Цэвэр, бохир ус	1,180,000.00	1,200,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	43,277,205.00	50,323,245.00
210401	Бичиг хэрэг	2,106,300.00	1,767,400.00
210402	Тээвэр, шатахуун	30,938,230.00	39,946,945.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,567,000.00	1,747,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,270,000.00	2,839,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,395,675.00	4,022,100.00
2105	Нормативт зардал	122,055,659.00	70,128,622.50
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	90,301,924.00	55,151,572.50
210502	Хоол, хүнс	28,421,733.00	13,837,050.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,332,002.00	1,140,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,500,000.00	31,530,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,500,000.00	19,270,000.00

210602	Тавилга	00.00	8,400,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	500,000.00	860,000.00
210604	Урсгал засвар	1,500,000.00	3,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	700,000.00	2,290,000.00
210702	Дотоод албан томилолт	700,000.00	2,290,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,756,035.00	987,510.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	288,000.00	288,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	110,600.00	140,700.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	55,010.00	151,410.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	48,400.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	636,000.00	319,000.00
210807	Газрын төлбөр	24,728.00	55,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,514,400.00	3,717,800.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,514,400.00	3,717,800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	39,190,263.00	43,150,730.81
2132	Бусад урсгал шилжүүлэг	36,600,000.00	23,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	36,600,000.00	23,000,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,590,263.00	2,716,785.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,590,263.00	2,716,785.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	17,433,945.81
213505	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт	00.00	17,433,945.81
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	17,433,945.81	12,277,615.01
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	17,433,945.81	12,277,615.01
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	17,433,945.81
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	17,433,945.81	29,711,560.82

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Төгрөг/
					Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	00.00	00.00

C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	256,471,533.00	288,751,758.29	176,465,392.69	721,688,683.98
D01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	256,471,533.00	288,751,758.29	176,465,392.69	721,688,683.98
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	359,265.38	359,265.38
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	256,471,533.00	288,751,758.29	176,824,658.07	722,047,949.36
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-359,265.38	00.00	-359,265.38
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	1,131,617.03	1,131,617.03
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	256,471,533.00	288,392,492.91	177,956,275.10	722,820,301.01

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	82,938,100.00	89,179,419.00	-6,241,319.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	82,938,100.00	89,179,419.00	-6,241,319.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	82,938,100.00	66,179,419.00	16,758,681.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	61,172,400.00	45,560,055.00	15,612,345.00
210101	Үндсэн цалин	54,101,200.00	43,882,055.00	10,219,145.00
210102	Нэмэгдэл	968,000.00	00.00	968,000.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	968,000.00	838,000.00	130,000.00
210104	Урамшуулал	4,295,200.00	00.00	4,295,200.00
210105	Гэрээт ажлын хөлс	840,000.00	840,000.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7,646,500.00	5,867,214.00	1,779,286.00
210201	Тэтгэврийн даатгал	5,199,600.00	4,015,411.80	1,184,188.20
210202	Тэтгэмжийн даатгал	611,800.00	472,400.55	139,399.45
210203	ҮОМШӨ-ний даатгал	489,300.00	367,840.43	121,459.57
210204	Ажилгүйдлийн даатгал	122,300.00	91,960.12	30,339.88
210205	Эрүүл мэндийн даатгал	1,223,500.00	919,601.10	303,898.90
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	00.00	5,094,600.00	-5,094,600.00
210302	Түлш, халаалт	00.00	5,094,600.00	-5,094,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,010,200.00	1,919,975.00	3,090,225.00
210401	Бичиг хэрэг	266,600.00	17,500.00	249,100.00
210402	Тээвэр, шатахуун	3,315,200.00	1,636,475.00	1,678,725.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	253,400.00	141,000.00	112,400.00
210404	Ном, хэвлэл	16,600.00	00.00	16,600.00

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	533,400.00	00.00	533,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	625,000.00	125,000.00	500,000.00
2105	Нормативт зардал	6,678,600.00	7,587,575.00	-908,975.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	5,012,000.00	6,382,575.00	-1,370,575.00
210502	Хоол, хүнс	1,250,000.00	1,205,000.00	45,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	416,600.00	00.00	416,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,458,400.00	00.00	1,458,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	750,000.00	00.00	750,000.00
210602	Тавилга	00.00	00.00	00.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	333,400.00	00.00	333,400.00
210604	Урсгал засвар	375,000.00	00.00	375,000.00
2107	Томилолт, зочны зардал	191,600.00	150,000.00	41,600.00
210702	Дотоод албан томилолт	191,600.00	150,000.00	41,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	223,200.00	00.00	223,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	50,000.00	00.00	50,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	60,000.00	00.00	60,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	18,400.00	00.00	18,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	9,200.00	00.00	9,200.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	9,200.00	00.00	9,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	72,000.00	00.00	72,000.00
210807	Газрын төлбөр	4,400.00	00.00	4,400.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	557,200.00	00.00	557,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	23000000.00	23,000,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	00.00	23,000,000.00	23,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	23,000,000.00	23,000,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	82,938,100.00	139,437,550.00	56,499,450.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	00.00	82,938,100.00	82,938,100.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	00.00	82,938,100.00	82,938,100.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	00.00	6,112,600.00	-6,112,600.00
132001	Орон нутгийн төсвөөс	00.00	6,112,600.00	-6,112,600.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих			00.00
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	82,938,100.00	50,386,850.00	32,551,250.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	82,938,100.00	50,386,850.00	32,551,250.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	17,433,945.81	17,433,945.81
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	79,900,936.81	79,900,936.81
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	01.00	01.00	00.00

610001	Төсвийн байгууллага	01.00	01.00	00.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	23.00	23.00	00.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	00.00
620002	Гүйцэтгэх ажилтан	17.00	17.00	00.00
620003	Үйлчлэх ажилтан	04.00	04.00	00.00
620004	Гэрээт ажилтан	01.00	01.00	00.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	23.00	23.00	00.00
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	18.00	18.00	00.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	04.00	04.00	00.00
650010	Гэрээт ажилтан	01.00	01.00	00.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Малчин сумын Эрүүл мэндийн төв нь үйлчлүүлэгчдэд ээлтэй, чанартай, тэгш хүртээмжтэй, эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг үзүүлэн, нийгмийн эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулж, өвчлөл эндэгдлийг бууруулахад чиглэн үйл ажиллагаагаа явуулж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ✓ Эрүүл мэндийн тухай хууль - 2021 оны 05 дугаар сарын 05-ны өдөр батлагдсан.
- ✓ Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль - 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдөр нэмэлт өөрчлөлт оруулсан.
- ✓ Эрүүл мэндийн даатгалын тухай хууль - 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдөр нэмэлт өөрчлөлт оруулсан.
- ✓ Хөдөлмөрийн тухай хууль - Шинэчлэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн.
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хууль - 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр батлагдсан.
- ✓ Төрийн албаны тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 05-ны өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр нэмэлт өөрчлөлтүүд оруулсан байна.
- ✓ Төсвийн тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 01-ний өдөр, 8 дугаар сарын 29-ний өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр
- ✓ Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам"
- ✓ Засгийн газрын 2019 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 276 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

- ✓ Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 107 дугаар тогтоолын 7 дугаар хавсралт
- ✓ Сангийн сайдын 2022 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 120 дугаар тушаал "Албан томилолтын зардлын тариф" тус тус нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Малчин сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Малчин сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,131.7 мянган төгрөгөөр буюу 1.5 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	17,433.9	29,711.6	12,277.7
Авлага	47,097.2		-47,097.2
Бараа материал	19,849.8	41,174.4	21,324.6
Үндсэн хөрөнгө	637,307.7	651,934.3	14,626.6
Нийт хөрөнгө	721,688.6	722,820.3	1,131.7
Өр төлбөр			
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	721,688.6	722,820.3	1,131.7
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	721,688.6	722,820.3	1,131.7

Төрийн сан дахь харилцах дансны үлдэгдэл нь өмнөх оны үзүүлэлтээс 12,277.7 мянган төгрөгөөр өссөн байна.

Авлага дансны эхний үлдэгдэл нь 47,097.2 мянган төгрөг байсан нь эрүүл мэндийн даатгалын байгууллагаас авах санхүүжилтийн дутууг тайлант онд бүрэн авсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 41,174.4 мянган төгрөг болж 21,324.6 мянган төгрөгөөр өссөн аж ахуйн материал болон эм боох материалыг эрүүл мэндийн газраас үнэ төлбөргүй хүлээн авснаас шалтгаалжээ. Бараа материалын дансны үлдэгдэлд худалдаж авсан ашиглалтгүй бараа материал байхгүй болно.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 651,934.3 мянган төгрөг болж 14,626.6 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь Эрүүл мэндийн газраас 6,787.8 мянга, орон нутгийн хөгжлийн сангаас 28,000.0 мянга, цахим төслөөр 902.8 мянган төгрөгийн үнэ төлбөргүй машин тоног төхөөрөмж, эд хогшил ирсэнтэй холбоотой байна. Тайлант онд аймаг, сумын ИТХ-ын захирамжаар нийт 18,522.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө актласан байна

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 722,826.3 мянган төгрөг болж 1,131.7 мянган төгрөгөөр өссөн нь үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдлээс шалтгаалж өссөн байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар тайлант үеийн үр дүн нь 1,131.6 мянган төгрөг болж өмнөх оны үр дүнгээс 0.06 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 509,591.3 мянга, орон нутгийн төсвөөс 26,487.1 мянга, эрүүл мэндийн даатгалаас 27,362.4 мянган төгрөг нийт зарлагыг 563,440.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас зардлыг 104,597.8 мянган төгрөгөөр өсгөж баталсан байна. Энэ нь 2022 оноос эрүүл мэндийн байгууллагын нэг иргэн тооцсон зардал, үйл ажиллагааны гүйцэтгэлд суурилсан нь шалтгаалсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 668,038.6 мянган төгрөг болгож тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 620,032.5 мянган төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сан, 26,487.1 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс бүрдүүлсэн байна.

Гүйцэтгэлээр эрүүл мэндийн даатгалын сангаас 617,732.7 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 26,487.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 611,791.5 мянган төгрөгийг зарцуулж, улсын төсвийн дансанд 29,711.6

мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Орон нутгийн төсвийн дансанд 2,716.8 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл
/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Улсын төсөв	620,032.5	611,791.5	8,224.0	98.6%
	Орон нутгийн төсөв	26,487.1	26,487.1		100%

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 611,791.5 мянган төгрөг буюу 91.5 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвөөс 29,711.6 мянган төгрөгийг хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “Нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Тайлант онд Малчин сумын Эрүүл мэндийн төвийн нэмэлт санхүүжилтийн дансаар орлого, зарлага гараагүй байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Малчин сумын Эрүүл мэндийн төв нь тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Малчин сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Увс Финанс Аудит” ХХК-ийн аудитор Я.Тунгалаг гүйцэтгэж, анхан шатны хяналтыг захирал Я.Нарантуяа, чанарын хяналтыг Увс аймгийн Төрийн аудитын газрын аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Малчин сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Увс Финанс Аудит” ХХК –д 2023 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 02 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 668.9 сая төгрөгөөс 1 хувиар буюу 6.6 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 686.3 сая төгрөгийн 1 хувиар буюу 6.8 сая төгрөгөөр тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Малчин сумын Эрүүл мэндийн төвийн хувьд Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор хамаарах зүйл заалтын хүрээнд зөрчил гараагүй байна. /АБ-4/

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс байршуулах хугацаа болоогүй 2, хугацаандаа оруулсан 149 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Малчин сумын Эрүүл мэндийн төв нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь хэсэгт “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Малчин сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмж өгөөгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Малчин сумын Эрүүл мэндийн төвийн хувьд дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар зөрчил илрээгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  /М.БАТСУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР

/М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

"УВС ФИНАНС АУДИТ" ХХК-ИЙН

 /Я.ТУНГАЛАГ/

2023 оны 02 дугаар сарын 06-ны өдөр